



Тунхаг бичиг

Залуу болон залуу үнэлгээчдийн санааг болон байр суурийг үнэлгээний ажилд үр бүтээлтэйгээр хамрагдуулах тухай уриалга

Дэлхий даяарх үнэлгээний нийгэмлэгийн гишүүд, Засгийн газрууд, Парламентын гишүүд, Мэргэжлийн үнэлгээний сайн дурын байгууллагууд (VOPEs), НҮБ-ын агентлагууд, үнэлгээчид, эрдэм шинжилгээний байгууллагууд, хувийн хэвшил, хөгжлийн салбар, бид бүхэн,

Залуу, шинээр гарч ирж буй үнэлгээчдэд дэлхийн үнэлгээний соёлыг төлөвшүүлэхэд идэвхтэй хувь нэмрээ оруулж, нийгмийн шударга ёс, тэгш байдлыг хангасан тогтвортой, хүртээмжтэй, эрх тэгш дэлхийг бий болгохын тулд үнэлгээний боловсон хүчийг нэмэгдүүлэхийг хүлээн зөвшөөрөх;

Тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор үнэлгээний үйл явц, үнэлгээний нөлөөллийн үйл ажиллагаанд залуус болон шинэ үнэлгээчдийг үр бүтээлтэйгээр хамруулах, дэмжих үүрэг, хариуцлагыг хүлээх;

Залуу болон шинээр гарч ирж буй үнэлгээчдийн мэргэжлийн чадавхыг бэхжүүлэхэд стратегийн болон хамтын нэгдсэн хүчин чармайлт гаргахыг хичээх;

Үнэлгээг санаачлах, хөгжүүлэх, хэрэглээнд оруулах, мөн залуустай хамтран ажиллах замаар олон талт байдалд ач холбогдол өгч, үнэлгээний үйл ажиллагаанд залуусын бодит ба үр бүтээл, үр дүнтэй оролцоог дэмжих, мөн түүнчлэн сайжруулахыг зорьж байна. Ингэхдээ залуус болон шинэ үнэлгээчдийг үнэлгээний бүх үе шатанд оролцуулахыг зорих бөгөөд үүнд:

- Үнэлгээний мэдээлэл цуглуулахдаа ялгаатай харах өнцөг, бодит жишээг олохын тулд залуучуудын нийгмийн цөөнх бүлэгт илүү анхаарал хандуулах
- Үнэлгээний багийн ахлах гишүүдтэй хамтран ажилладаг үнэлгээчид

- Үнэлгээний үйл явцын гол үр дүнгийн талаарх ойлголтыг өгдөг зөвлөхүүд
- Үнэлгээний үйл явцыг комиссын гишүүд эсвэл менежерүүдтэй хамтран зөвлөж, удирдан чиглүүлдэг шийдвэр гаргагч нар
- Үнэлгээний ач холбогдлыг дэмжигч байх зэрэг байдлаар оролцуулах

Үйл ажиллагааны явцыг дүгнэх, өөрчлөлт, арга хэмжээнд сурсан мэдсэнээ хэрэглэхийн зэрэгцээ үнэлгээнд залуус, шинэ үнэлгээчдийг үр бүтээлтэйгээр оролцуулах нь нэг удаагийн ажил биш, тасралтгүй үргэлжлэх үйл явц гэдгийг баталъя.

Бид бүхэн/би үнэлгээний чиглэлээр залуучуудын түүчээ болохоо амлаж байна!

Тунхаг бичигт гарын үсэг зурах